



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 20 өдөр


Дугаар А/242

Номгон

Дэлхийн мөнгөний долоо хоног 2026
аяны үйл ажиллагаанд дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн мөнгөний долоо хоног-2026 аяны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.
2. Аяны үйл ажиллагаанд шаардагдах 5,206,300 (Таван сая хоёр зуун зургаан мянга гурван зуун) төгрөгийн зардлын тооцоог хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.
3. Үйл ажиллагааг хөтөлбөрт тусгагдсаны дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

626010640

№	Он сар	Зардлын нэр	Хүний тоо	Нэр бүрийн үнэ	Мөнгөн дүн	АЗДТ
1	2	3	4	5	6	7
1	2026.04.10	Хүлээн авалтын хоол	40	76,500	3,060,000	3,060,000
2	2026.04.09	Оройн хоол	5	45,020	225,100	225,100
3		Бэлэг дурсгал	1	450000	450,000	450,000
4		Мөнгөн аяга	1	700000	700,000	700,000
5		Хадаг	2	10000	20,000	20,000
6		Хонины мах	27	18000	486,000	486,000
7		Цэвэр ус	312	850	265,200	265200
		Дүн			5,206,300	5,206,300

000

ЗАРДЛЫН ТООЦОО

